

## Ерөнхий мэргэжлийн эмч

### Тестийн зөв хариулт

1-C, 2-B, 3-A, 4-C, 5-D, 6-C, 7-B, 8-C, 9-A, 10-D, 11-E, 12-C, 13-B, 14-A, 15-B, 16-A, 17-C, 18-D, 19-D, 20-C, 21-D, 22-E, 23-C, 24-B, 25-E, 26-E, 27-B, 28-A, 29-E, 30-D, 31-E, 32-B, 33-E, 34-C, 35-A, 36-C, 37-D, 38-D, 39-D, 40-A, 41-C, 42-B, 43-D, 44-E, 45-B, 46-E, 47-C, 48-B, 49-B, 50-A, 51-D, 52-C, 53-A, 54-B, 55-E, 56-B, 57-E, 58-B, 59-B, 60-E, 61-B, 62-D, 63-E, 64-A, 65-D, 66-A, 67-C, 68-A, 69-E, 70-E, 71-D, 72-C, 73-E, 74-A, 75-A, 76-A, 77-E, 78-E, 79-C, 80-A, 81-B, 82-B, 83-E, 84-E, 85-B, 86-D, 87-B, 88-A, 89-C, 90-D, 91-B, 92-D, 93-C, 94-A, 95-E, 96-D, 97-D, 98-E, 99-E, 100-D

## Тестийн түлхүүр

1. Нэг сонголттой тест ( Зөвхөн 1 хариулт зөв байх ) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E

гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.

2. Олон сонголттой тест ( Хэдэн ч хариулт зөв байж болох )

1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (A.)

1, 2, 3, 4 дүгээр хариултууд зөв бол (B.)

2 ба 4 дүгээр хариултууд зөв бол (C.)

Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)

Бүх хариулт зөв бол (E.)

3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)

Зөв, Зөв, Зөв (A.)

Зөв, Зөв, Буруу (B.)

Зөв, Буруу, Буруу (C.)

Буруу, Зөв, Буруу (D.)

Буруу, Буруу, Буруу (E.)

/1./ Өвчтөн Ц., нас 44, бие ядарна, бөөлжис хүрнэ, хоолонд дургүй, баруун хавирганы нумаар унжиж өвдөнө гэсэн зовиуртай. Сүүлийн хоёр жил өвдөж байна. Архи дарс уух, өөх тостой хоол идэхээр бие өвддөг гэсэн өгүүлэмжтэй. Арьс салст шарлангуй, өтгөн цайвардуу, шээс “пиво шиг өнгөтэй. Пульс 1 минутанд 72, зүрх судас болон уушиг хэвийн. Хэвлий зөөлөн, дарж үзэхэд баруун хавирганы нумаар эмзэглэлтэй, элэг хавирганы нумаас доош 5 см томорсон, ирмэг мохоо. Элэгний хэмжээ /Курловын аргаар/ 15\*20\*18, дэлүү томроогүй. Өвчтний биохимийн шинжилгээнд ямар өөрчлөлт илрэх магадлалтай вэ?

A. Цусанд шууд (холбоот бус) билирубин ихсэх

B. Цусанд шууд (холбоот бус) билирубин болон АЛТ, АСТ ихсэх

C. Цусанд шууд бус (холбоот)билирубин болон АЛТ, АСТ ихсэх

D. Цусанд шууд бус (холбоот) билирубин болон шүлтлэг фосфотаз, холестерин ихсэх

/2./ Судалгаагаар баас хатах хам шинжтэй хүмүүст гэдэс суллагдах хугацаа нь

A. 36.0+1.94 минут

B. 106+0.18 минут

C. 45+1.18 минут

D. 96+0.98

E. Бүгд зөв

/3./ Аль нь элэгний анхдагч хавдрын үед илрэхгүй вэ?

A. Сийвэнгийн церулоплазмин багассаны улмаас мэдрэлийн өөрчлөлт үүсч, чичрэх татах хам шинж, гиперкинез илрэх

B. Антибиотик эмчилгээнд дарагдахгүй урт хугацаагаар халуурах

C. Эмнэлзүйн шинж тэмдэг бүдэг байж, архаг гепатит хэлбэрээр явагдах

/4./ Ходоод, дээд гэдэсний шархлааны улмаас хүндрэлийн улмаас үүссэн нарийсалыг хэрхэн ангилдаг вэ?

- A. Ээнэгшилтэй, ээнэгшилгүй
- B. Намжмал, сэдэрсэн
- C. Үйл ажиллагааны, бүтцийн
- D. Хэвийн, хэвийн бус
- E. Бөгжилсөн, бөгжилөөгүй

/5./ Доорх өөрчлөлтүүд илэрсэн нойр булчирхайн цочмог үрэвсэл бүхий үйлчлүүлэгчийн аль үзүүлэлт үйлчлүүлэгчийн тавилан муу байгааг болон нас барах эрсдлийг нэмэгдүүлж байна вэ?

- A. БЖИ >25 кг/м<sup>2</sup>
- B. Гематокрит >40%
- C. Липаза >1000IU/l
- D. PaO<sub>2</sub><60ммуб
- E. Цагаан эсийн тоо >10,000

/6./ Асцитийн шингэнд нейтрофил эсийн тоо >250 мм<sup>3</sup> тохиолдолд ямар эмгэгийг сэжиглэх вэ?

- A. Сүрьеэгийн шалтгаантай асцит
- B. Хавдарын шалтгаантай асцит
- C. Аяндаа үүсэх перитонит
- D. Зүрхний дутагдлын шалтгаантай асцит
- E. Элэгний циррозын шалтгаантай асцит

/7./ Бүдүүн гэдсэнд оршин биед ашигтай нянгийн төлөөлөгч

- A. Бифидумбактер, лактобактер, гэдэсний савханцар, энтеркокк
- B. Агааргүйтэн нян 99%, агаартан нян 1%-ийг эзэлдэг
- C. Гэдэсний савханцар тэргүүтэй агаартан нян давамгайлна

/8./ С вирусын эсрэг эмчилгээ хийх явцад эмчилгээний хяналтын шинжилгээг хэзээ хийх вэ?

A. Гематологи сард 2 удаа, биохими сард нэг, вирусологи эмчилгээний эхлэл болон төгсгөлд, гистологи нэг удаа

B. Гематологи сард нэг, биохими сард 2, вирусологи сард 1, гистологи сар тутам

C. Гематологи 2 долоо хоног тутамд, биохими 4 долоо хоног тутам, вирусологи 3 сар тутам, гистологи 6-12 сарын дараа

/9./ Архаг, чулуугүй холециститыг үүсэгдэг гол шалтгааныг нэрлэнэ үү.

- A. Халдвар
- B. Элэгний бодис
- C. Элэгний хатуурал
- D. Цөсний чулуу
- E. Дуоденостаз

/10./ Ходоодны тархмал үрэвсэл, голомтот хатингаршил, гэдэсний метаплази илэрсэн, ходоодны хүчил багассан тохиолдолд эмчилгээний тактикийг сонгоно уу?

- A. Лансопризол20мг\*2+кларитромицин500мг\*2+метронидазол500мг\*2удаа
- B. Омепразол20мг\*2+кларитромицин500мг\*2+метронидазол500мг\*2удаа

C.

Омепразол20мг\*2+денол120мг\*2+кларитромицин500мг\*2+метронидазол500мг\*2

- D. Денол120мг\*2 удаа+кларитромицин500мг\*2+метронидазол500мг\*2удаа//

- Е. Денол120мг\*2+кларитромицин500мг\*2+ранитидин150мг\*2
- /11./ Архаг энтретийн үед биохимийн шинжилгээнд илрэхгүй шинж нь аль вэ?
- А. Сийвэнд агуулагдах уураг
  - В. Альбумин
  - С. Өөх тос
  - Д. Эрдэс бодис
  - Е. Нүүрс ус
- /12./ Цөсний ялгаралтыг идэвхижүүлдэг гормон аль нь вэ?
- А. Глюкагон
  - В. Адреналин
  - С. Холецистокинин
  - Д. Кортизол
  - Е. Инсулин
- /13./ Интерферон эмчилгээний үед хамгийн их тохиолддог гаж нөлөөг нэрлэ.
- А. Кардиопати, депресссиндром, гиперурикеми, гипергликеми,
  - В. Грипп төст синдром, депресс синдром, цитопенийн синдром, алопеци
  - С. Таргалалт, дисменорей, даралтихсэх, суулгах
- /14./ Улаан хоолойн агчил өвчний үе шат болон хүндрэлийн 2 үе шатанд илрэх өөрчлөлтийг нэрлэнэ үү?
- А. Улаан хоолойн тэлэгдэл бага зэрэг үүссэн байх бөгөөд хоолны агуулагдахуун удаан хугацаанд хуримтлагдсан байна
  - В. Тогтвортойгоор улаан хоолой тэлэгдэнэ
  - С. Ахалазийн эмнэлзүйн шинжүүд тод илэрнэ
  - Д. Улаан хоолойд хуримтлагдах хоолны агуулагдахуун түр зуур саатах ба улаан хоолойн булчин сулрах үед аяндаа ходоод руу орно
  - Е. Улаан хоолойн доод хэсгээр сорвижилт үүссэн байна
- /15./ Элэгний анхдагч билиарны циррозоор ямар хүн ихэвчлэн өвчлөх вэ
- А. Эрчүүд
  - В. Эмэгтэйчүүд
- /16./ 12 хуруу гэдэсний РН 4.0 болоход эргэж буцалтгүй идэвхээ алддаг нойр булчирхайн даавар
- А. Липаза
  - В. Химотрипсिन
  - С. Колипаза
  - Д. Липаза, колипаза
  - Е. Трипсин
- /17./ Иррогоскопийн аргаар юуг тодорхойлдог вэ?
- А. Гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөн
  - В. Гэдэсний хүрээ
  - С. Гэдэсний байрлал
  - Д. Гэдэсний сулрал
  - Е. Гэдэсний урт
- /18./ Өвчтөн Ц., нас 44, бие ядарна, бөөлжис хүрнэ, хоолонд дургүй, баруун хавирганы нумаар унжиж өвдөнө гэсэн зовиуртай. Сүүлийн хоёр жил өвдөж байна. Архи дарс уух, өөх тостой хоол идэхээр бие өвддөг гэсэн өгүүлэмжтэй. Арьс салст шарлангуй, өтгөн цайвардуу, шээс “пиво шиг өнгөтэй. Пульс 1 минутанд 72, зүрх

судас болон уушиг хэвийн. Хэвлий зөөлөн, дарж үзэхэд баруун хавирганы нумаар эмзэглэлтэй, элэг хавирганы нумаас доош 5 см томрсон, ирмэг мохоо. Элэгний хэмжээ /Курловын аргаар/ 15\*20\*18, дэлүү томроогүй. Урьдчилсан онош тавина уу.

- A. Элэгний цочмог үрэвсэл
- B. Элэгний хатуурал
- C. Гемолизийн шарлалт
- D. Элэгний архаг үрэвсэл
- E. Роторын хам шинж

/19./ Улаан хоолойн орчин (ph) хэд вэ?

- A. ph=1.5-2.5
- B. ph=9-10
- C. ph=7-8
- D. ph=5.5-7
- E. E. ph=2-3

/20./ Дараах эмүүдээс алийг нь холестаазын хам шинжийг эмчлэхэд хэрэглэх вэ?

- A. Аллохол
- B. Никотин
- C. Холестирамин
- D. Сирепар
- E. Оксафенамид

/21./ Өвөрмөц бус шархлаат өвчний үед бүдүүн гэдэсний хордлогот тэлэлт үүссэн эсвэл бүдүүн гэдэсний шарх цоорох гэж сэжиглэвэл ямар шинжилгээ хийх вэ.

- A. Колоноскопи
- B. Ирригоскопи
- C. Цусан дах хурц үеийн үзүүлэлтүүлийг тодорхойлох
- D. Хэвлийн хөндийн эрхтний тойм рентген зураг
- E. Хэвлийн хөндийн компьютер томограф

/22./ Нойр булчирхайн цочмог үрэвслийн хүнд хөнгөний зэргийг ямар шалгуураар үнэлэх вэ?

- A. “Түгшүүр шинж” илрэх
- B. Рокколын үнэлгээ
- C. Маннийн шалгуур
- D. Римийн I ба II шалгуур
- E. Рансоны шалгуур

/23./ D гепатитийн вирус нь дараах вирусаар халдварлагдсан үед элэгний эсэд нэвтрэн элгийг үрэвсүүлнэ:

- A. Вирус А
- B. Вирус С
- C. Вирус В

/24./ Архаг энтретийн үед шинжилгээнд гарах өөрчлөлтөөс аль нь илрэхгүй вэ?

- A. Өдөрт 1-3 суулгах
- B. Өнгө нь улаан
- C. Хэмжээ их
- D. Дутуу задарсан хоолны үлдэгдэлтэй
- E. Аль ч биш

/25./ Нойр булчирхайн архаг үрэвслийн үед гадаад шүүрлийн дутагдалтай үед аль эмийг сонгох вэ?

- A. Контрикал судсаар
- B. Антацид уулгах
- C. Шингэн юүлэх
- D. H2 блокатор уулгах
- E. Фестал уулгах

/26./ GERDQ асуумжийн аргыг оношлогоонд ашиглахад нийт оноо 8 ба түүнээс дээш бол ходоод улаан хоолойн сөөргөө өвчтэй байх магадлал хэдэн хувь гэж үздэг вэ

- A. 50%-аас бага
- B. 60%-аас дээш
- C. 70%-аас дээш
- D. 80%-аас доош
- E. 80%-аас дээш

/27./ Ихэвчлэн том зангилаат цирроз үүсгэнэ:

- A. Архи хэтрүүлэх
- B. Вирусын гепатит
- C. Хоолны дэглэм алдах
- D. Хоол боловсруулах замын өвчин

/28./ Давсны хүчил нь ямар эсээс ялгарах вэ?

- A. А. Ханын эс
- B. В. Нэмэлт эс
- C. С. Гол эс
- D. D. Завсрын эс
- E. E. Дотоод шүүрлийн эс

/29./ d-ксилозийн сорилоор юуг үздэг вэ?

- A. Уураг
- B. Нүүрс-ус
- C. Бактер
- D. Грам зэрэг нян
- E. Грам сөрөг нян

/30./ Гэдэсний дамжин өнгөрөх хугацааг тодорхойлдог амьсгалын сорил нь баас хатах хам шинжтэй хүнд хэд болж өөрчлөгдөх вэ?

- A. 4.2+0.2
- B. 5.4+0.2
- C. 4.5+0.4
- D. 5.4+0.3
- E. 3.4+0.2

/31./ Улаан хоолойн горойлтын онцлог

- A. Залгинуут горойж тээглэнэ
- B. Хахаж цацах
- C. Зовхи унжих
- D. Дуу гунших
- E. Залгиаснаас хойш өвчүүний ард горойно

/32./ Гэдэсний нянгийн өсгөвөр хийж болох орчин аль нь вэ?

- A. Биохимид

- В. Гэдэсний шүүсэнд
- С. Цусанд
- Д. Шээсэнд
- Е. Гэдэсний хананд

/33./ Ходоод, улаан хоолойн сөөргөө урсгалын өвчний шалбархайт хэлбэрийн “Д” зэргийн үед дуранд ямар өөрчлөлт илрэх вэ?.

А. Улаан хоолойн доод хэсэгт 5 мм хүртэл хэмжээтэй шалбархай 1 ба 2 хананд илрэх.

В. Улаан хоолойн доод хэсэгт 5 мм- с их хэмжээтэй шалбархай 1 ба 2 хананд үүсэх.

С. Шалбархайнууд хоорондоо нийлж улаан хоолойн доод хэсгийн гадаргуугын 65% хүртэл талбайг хамрах

Д. Шалбархайнууд хоорондоо нийлж улаан хоолойн доод хэсгийн гадаргуугын 75% хүртэл талбайг хамрах

Е. Шалбархай, шархлаа нь улаан хоолойн доод хэсгийн гадаргуугийн 75%-с их талбайг эзлэх, цус алдалт, сорвижил, нарийсал, эдийн хувирал, шархаар хүндрэх

/34./ Элэгний хатуурлын оношийг батлах шинжилгээ юу вэ.

- А. Биохими
- В. УЗИ
- С. Биопси
- Д. Изотопи
- Е. Компьютер томографи

/35./ Бүдүүн гэдэсний шүүрлийн агууламжийн онцлог?

- А. Бикарбонат
- В. Сиало-сульфамуцин
- С. Ходоодны хүчил
- Д. HCL
- Е. Цөсний хүчил

/36./ Улаан хоолойн үндсэн үүрэг юу бэ?

- А. Хоол хүнсийг залгих
- В. Хоолыг жижиглэх
- С. Хоолыг залгиураас ходоод руу дамжуулах
- Д. Гүрвэлзэх хөдөлгөөн хийх
- Е. Хэхрэх, гулгих

/37./ Имодиумын үйлчилгээг нэрлэнэ үү.

- А. Бактер устгах, нянгийн өсөлтийг дарангуйлах
- В. Ходоод гэдэсний хөдөлгөөн түргэсгэх
- С. Гэдэсний шүүрэл ялгаралтыг нэмэгдүүлэх
- Д. Гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөнийг саатуулах
- Е. Бодисын солилцоо сайжруулах

/38./ Доорхи бэлдмэлүүдээс цөсний хүчил агуулсан фермент нь аль нь вэ?

- А. Панкурмин
- В. Трифермент
- С. Мезим форте
- Д. Панзинорм
- Е. Фестал

/39./ Элэгний хатуурлын хүндрэлийн үед аль нь илрэхгүй вэ

- A. Улаан хоолойн өргөссөн венээс цус алдах
- B. Ком
- C. Элэгний хавдар
- D. Цөсний хүүдийн үрэвсэл
- E. Дээрх бүгд

/40./ Хеликобактериас ялгардаг ямар фермент эсийн хоорондын холбоог тасалж, нягтралыг бууруулан салслаг бүрхүүлийг нимгэрүүлдэг вэ?

- A. Протеаза
- B. Уреаза
- C. Цитотоксин
- D. Цитохромоксидаза
- E. Пепсин

/41./ Гэдэсний нянгийн бичил орчин өөрчлөгдөхөд дээрх шинж тэмдгүүдээс аль нь илүүц вэ?

- A. Гэдэс дүүрч цанхайх
- B. Аманд гашуун амтагдах
- C. Өмхий үнэртэй унгах
- D. Гэдэс хуржигнан дугарах
- E. Өтгөн хатах

/42./ Архины бус шалтгаант элэгний өөхжилтийн морфологийн шалгуур үзүүлэлт юу вэ.

- A. Элэгний эсийн өөхөн дистрофи тусдаа байх
- B. Элэгний эсийн өөхөн дистрофи нь үхжил, лимфогистиоцитарны нэвчдэс
- C. Дээрх хоеулаа

/43./ Ходоод, улаан хоолойн сөөргөө урсгалын өвчний шалбархайт хэлбэрийн “С” зэргийн үед дуранд ямар өөрчлөлт илрэх вэ?.

A. Улаан хоолойн доод хэсэгт 5 мм хүртэл хэмжээтэй шалбархай 1 ба 2 хананд илрэх.

B. Улаан хоолойн доод хэсэгт 5 мм- с их хэмжээтэй шалбархай 1 ба 2 хананд үүсэх.

C. Шалбархайнууд хоорондоо нийлж улаан хоолойн доод хэсгийн гадаргуугын 65% хүртэл талбайг хамрах

D. Шалбархайнууд хоорондоо нийлж улаан хоолойн доод хэсгийн гадаргуугын 75% хүртэл талбайг хамрах

E. Шалбархай, шархлаа нь улаан хоолойн доод хэсгийн гадаргуугийн 75%-с их талбайг эзлэх, цус алдалт, сорвижил, нарийсал, эдийн хувирал, шархаар хүндрэх

/44./ Порталь гипертензийн үед илрэхгүй шинжийг сонго.

- A. Хэвлийд шингэн хуримтлах
- B. Медузийн толгой
- C. Геморрой
- D. Улаан хоолойн вений варикоз өргөсөлт
- E. Шарлалт

/45./ Дээд гэдэсний булцууны арын хананы шарх голчлон ямар эрхтэн рүү нэвчих вэ?

- A. Бага чацархай руу голдуу нэвчинэ



- B. Нойр булчирхайн толгойн хэсэг рүү нэвчинэ
- C. Элэг рүү голдуу нэвчинэ
- D. Нойр булчирхайн их бие рүү голдуу нэвчинэ
- E. Цэсний хүүдий рүү голдуу нэвчинэ

/46./ Өтгөний хэдэн хувийг ус эзэлдэг вэ?

- A. 10-20%
- B. 25-30%
- C. 35-45%
- D. 65-70%
- E. 60-85%

/47./ Элэгний энцелопатийн үед тоо холбох тестийг энцелопатийн 1-2 зэрэгтэй хүн хэдэн секундэд биелүүлэх вэ?

- A.  $\leq 30$
- B. 31-50
- C. 51-80
- D. 81-120
- E.  $120 \leq$

/48./ Бүдүүн гэдэсний өвөрмөц бус шархлаат өвчний үед эдийн шинжилгээнд гарах өөрчлөлт

- A. Гэдэсний ханыг хамарсан үрэвслийн нэвчдэс, гүн шархлаа
- B. Криптийн буглаа, салстын улайлт өнгөц шархлаа
- C. Псевдополипоз

/49./ Дисфаги гэдэг нь:

- A. Шингэн юм уухад халгихад хахаж цацна.
- B. Залгих үйл ажиллагаа саадтай болж, залгихад төвөгтэй болсоноос үүсэх эмгэг мэдрэхүй юм.
- C. Залгих үед өвдөхийг хэлнэ.
- D. Цээж өвчүүний ард юм тээглэхийг хэлнэ.
- E. Залгих үед ханиаж найтаана.

/50./ Ходоод дээд гэдэсний шархлааны үед дурангийн шинжилгээгээр шархлааны идэвхжилийн зэрэг Al, Forrest Ia, IIa үед ямар тасагт хэвтүүлж эмчилэх вэ?

- A. Мэс заслын тасагт
- B. Дотрын тасагт
- C. Гэрээр
- D. Амбулаториор

/51./ Гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөн сайжруулах эмийг сонгоно уу.

- A. Сульфасалазин
- B. Метацин
- C. Метиндол
- D. Прозерин
- E. Имодаум

/52./ Аутоиммунны гепатитын үндсэн эмчилгээг сонгоно уу.

- A. Кортикостероид+ интерферон
- B. Цитостатик+ интерферон
- C. Кортикостероид+ цитостатик
- D. Урсодезоксихолевая кислота + кортикостероид

/53./ Холестерол хүний биеэс ялгарах гол зам аль нь вэ?

- A. Элгэнд цөсний хүчил болно
- B. Өөхний хүчил болж задарна
- C. Триглицерид болно
- D. Элгэнд бусад стеролуудыг үүсгэнэ
- E. Шээсээр ялгарна

/54./ Хеликобактериас ялгардаг ямар фермент ходоодны орчинг шүлтлэг болгон устөрөгчийн ионы эргэн шимэгдэлтийг алдагдуулж эдийн үхжил, хатингаршил үүсгэх вэ?

- A. Протеаза
- B. Уреаза
- C. Цитотоксин
- D. Цитохромоксидаза
- E. Пепсин

/55./ Архины бус шалтгаант элэгний өөхжилтийн үед илрэх эмнэлзүйн шинжийг ялгана уу?

- A. Вирусын халдвар байхгүй
- B. Биеийн жин нэмэгдэх
- C. Гиперлипидеми, триглицерид ихэссэн
- D. Архи хэрэглэдэггүй
- E. Дээрх бүгд

/56./ Ходоодны дээд хэсэгт байршилтай шархлааны үед хэвлийн аль хэсэгт ямар өвдөлт илрэх вэ?

- A. Аюулхай орчим хоол идсэнээс 20 минутын дараа эрт өвдөлт илрэнэ
- B. Аюулхай орчим хоол идсэнээс 30 минутаас 1 цагийн дараа эрт өвдөлт илрэнэ
- C. Аюулхай орчим хоол идсэнээс 30 минутаас 1 цагийн дараа хожуу өвдөлт илрэнэ
- D. Аюулхай орчим хоол идсэнээс 1 цагийн дараа хожуу өвдөлт илрэнэ
- E. Аюулхай орчим хоол идсэнээс 1 цаг 30 минутын дараа хожуу өвдөлт илрэнэ.

/57./ Элэгний комын үеийн Глазгогийн шалгуураар хэдэн оноотой байвал хүнд зэргийн энцефалопати гэж үздэг вэ?

- A. 8
- B. 9
- C.  $\geq 10$
- D.  $\geq 11$
- E.  $\leq 12$

/58./ Хос гэдсэнд хаймсуур тавихад 2-р үе хэдэн минут үргэлжлэх вэ?

- A. 1-5
- B. 3-5
- C. 5-10
- D. 10-20
- E. 20-30

/59./ Ходоод дээд гэдэсний шархлааны үед дурангийн шинжилгээгээр шархлааны идэвхжилийн зэрэг All, Forrest IIb, III үед ямар тасагт хэвтүүлж эмчилэх вэ?

- A. Мэс заслын тасагт
- B. Дотрын тасагт

- C. Гэрээр  
D. Амбулаториор
- /60./ Цөсний хүүдийн архаг үрэвсэл намдаж буй үед ямар зөвлөгөө өгөх вэ?  
A. Цөс хөөх эм  
B. Антибиотик  
C. 5а хоол  
D. Булчин сулруулах эм  
E. Дасгал, идэвхитэй хөдөлгөөн
- /61./ Даамжрах элэгний эсийн дутагдлын үеийн эмчилгээний зарчмыг сонго.  
A. Кортикостероид эмчилгээ өндөр тунгаар  
B. Түр зуур орлуулах эмчилгээ, цаашид элэг шилжүүлэн суулгах  
C. Кортикостероид эмчилгээ өндөр тунгаар, цитостатик  
D. Интерферон өндөр тунгаар
- /62./ Элэгний хатуурлын оношлогоонд чухал ач холбогдолтой биохимийн үзүүлэлт:  
A. Бромсульфалеины сорил  
B. Билирубин  
C. Трансаминаз  
D. Аль нь ч биш  
E. Дээрх бүгд
- /63./ Механик шарлалтын үед арьс загатнах шалтгаан  
A. Гемоглобины синтезын алдагдлаас  
B. Элэгний цусан хангамж буурснаас  
C. Үүдэн венийн даралт ихэссэнээс  
D. Эмийн харшлын улмаас  
E. Цусанд цөсний хүчлийн хэмжээ ихэссэнээс
- /64./ Хеликобактери нь  
A. Хүчиллэг орчинд тэсвэртэй, грам сөрөг, нэг талдаа багц шилбүүр бүхий хөдөлгөөнт бактери  
B. Кампилобактери юм  
C. Шүлтлэг орчинд тэсвэртэй, грам эерэг, нэг талдаа багц шилбүүр бүхий хөдөлгөөнт бактери  
D. Хүчиллэг орчинд тэсвэртэй, грам эерэг, нэг талдаа багц шилбүүр бүхий хөдөлгөөнт бактери  
E. Грам эерэг, нэг талдаа багц шилбүүр бүхий хөдөлгөөнт бактери
- /65./ Нян үржихгүй байх нөхцөлд хамаарахгүй хүчин зүйлийг нэрлэнэ үү?  
A. Гэдэсний ханын бүрэн бүтэн байдал  
B. Ходоодны хүчлийн шүүрэл  
C. Гэдэсний байнгын гүрвэлзэх хөдөлгөөн  
D. Үндсэн нянгийн тоо буурах  
E. Иммуноглобулин А-ийн ялгаралт
- /66./ Элэгний архаг эмгэг үүсгэдэг хамгийн тархмал вирусын халдварыг сонгоно уу?  
A. HBV- вирусын халдвар  
B. HCV- вирусын халдвар  
C. HAV- вирусын халдвар  
D. HBV/HDV-вирусын халдвар, HDV-вирусын халдвар
- /67./ Улаан хоолойн 2-р нарийсалын байрлалыг хэлнэ үү?

- A. 5, 6-р хүзүүний харалдаа
  - B. 6, 7-р хүзүүний харалдаа
  - C. Сээр нурууны 4, 5-р нугалмын харалдаа
  - D. Сээр нурууны 5, 6-р нугалмын харалдаа
  - E. Сээр нурууны 7, 8-р нугалмын харалдаа
- /68./ Элэгний хатуурлын үед ямар морфологийн өөрчлөлт гарах вэ?
- A. Фиброз, зангилаат өөрчлөлт, судасны судал өөрчлөгдөх
  - B. Фиброз, үрэвслийн нэвчдэс
  - C. Өөхөн дистрофи
  - D. Аль нь ч биш
- /69./ APUD тогтолцооны D эс ямар даавар ялгаруулж, физиологийн ямар үүрэг гүйцэтгэх вэ?
- A. Серотонин ялгаруулж, салст ялгаралтыг сайжруулна
  - B. Гастрин ялгаруулж, давсны хүчил ялгаралт болон пепсиногеныг идэвхжүүлнэ
  - C. Бомбезин ялгаруулж, нойр булчирхайн шүүрлийг идэвхжүүлнэ
  - D. Секретин ялгаруулж, давсны хүчил ялгаралтыг саатуулна
  - E. Соматостатин ялгаруулж уургийн нийлэгжилтийг саатуулна
- /70./ Гэдэсний агуулагдахуун хоорондоо холилдон, боловсруулалт үргэлжлэн, ус шимэгдэх үйл явц ямар агшилтын үр дүнд явагдах вэ?
- A. Гүрвэлзэх
  - B. Нарийсах
  - C. Туух
  - D. Эсрэг урсгал
  - E. Хэсэгчилсэн
- /71./ Гепатореналь хамшинжийн үед хийх судас агшаах эмчилгээн зогсоох шалгуурыг нэрлэнэ үү?
- A. сийвэнгийн креатининий хэмжээ 2,0мг/дл-с ихсэх
  - B. сийвэнгийн креатининий хэмжээ 1,0мг/дл-с ихсэх
  - C. сийвэнгийн калийн хэмжээ 120ммоль/л-с буурах
  - D. сийвэнгийн креатининий хэмжээ 1,5мг/дл-с буурах
  - E. сийвэнгийн креатининий хэмжээ 2,5мг/дл-с буурах
- /72./ Элэгний өөхжилтийн үед эцсийн оношийг дараах шинжилгээгээр батална:
- A. Компьютер томографи
  - B. MRI
  - C. Элэгний биопси
- /73./ Кроны өвчний элбэг тохиолдох хэлбэрийг нэрлэнэ үү.
- A. Гранулематозный колит
  - B. Гранулематозный гастрит
  - C. Тотальный илеит
  - D. Проктосигмоидит
  - E. Терминальный илеит
- /74./ Нойр булчирхайн шүүс ямар найрлагатай вэ?
- A. Электролит, фермент
  - B. Na, K, Ca, Se
  - C. Гидрокарбонат, ус эрдэс
  - D. Ферментүүд

Е. Ус, хүчил

/75./ Элэгний ком үүсэх шинж илэрвэл, хоолонд дараах зүйлийг хязгаарлана

- А. Уураг
- В. Өөх тос
- С. Нүүрс ус
- Д. Шингэн
- Е. Минераль давс

/76./ Бүдүүн гэдэсний нянгийн бичил орчинг өөрчлөхөд .....

- А. Үндсэн нянгийн тоо олширч, эмгэг төрөгчийн тоо буурна
- В. Үндсэн нянгийн тоо буурч, эмгэг төрөгчийн тоо ихсэнэ
- С. Үндсэн нянгийн тоо, эмгэг төрөгчийн тоо тэнцүү
- Д. Үндсэн нянгийн тоо олширч, эмгэг төрөгчийн тоо олширно
- Е. Үндсэн нянгийн тоо буурч, эмгэг төрөгчийн тоо буурна

/77./ Улаан хоолойн байрлалыг хэлнэ үү?

- А. Улаан хоолой 3-р хүзүүний түвшинд төвөнхийн болон мөгөөрсний араас эхлэн 8, 9-р сээр нуруу хүртэл үргэлжилнэ
- В. Улаан хоолой 4-р хүзүүний түвшинд төвөнхийн болон мөгөөрсний араас эхлэн 10-р сээр нуруу хүртэл үргэлжилнэ
- С. Улаан хоолой 3, 4-р хүзүүний түвшинд төвөнхийн болон мөгөөрсний араас эхлэн 9, 10-р сээр нуруу хүртэл үргэлжилнэ
- Д. Улаан хоолой 4, 5-р хүзүүний түвшинд төвөнхийн болон мөгөөрсний араас эхлэн 9, 10-р сээр нуруу хүртэл үргэлжилнэ
- Е. Улаан хоолой 6-р хүзүүний түвшинд төвөнхийн болон мөгөөрсний араас эхлэн 11-р сээр нуруу хүртэл үргэлжилнэ

/78./ Элэгний хатуурлын үед илрэхгүй хам шинж (шинж тэмдэг)-ийг сонгоно уу.

- А. Бижийн хам шинж
- В. Мэдрэл сульдлын хам шинж
- С. Гэдсэнд хий дүүрэх
- Д. Порталь гипертензи
- Е. Хурц өвдөлт

/79./ Нарийн гэдэсний гүрвэлзэх хөдөлгөөн хэдийд ихэсдэг вэ?

- А. Өтгөнөө гадагшлуулах үед
- В. Хоол идэх хүсэл төрсөн үед
- С. Хоол идсэний дараа
- Д. Ходоодны фермент ялгарсаны дараа
- Е. Цөс ялгарсаны дараа

/80./ БГӨШҮ-ийн үед хэрэглэх үрэвслийн эсрэг бэлдмэл

- А. Сульфасалазин, салазометоксин, салазопиридазин, месасализин
- В. Сульгин, фталазол, тримексазол, септрин
- С. Левомецетин, трихопол, ампициллин, тетрациклин

/81./ Аутоиммуны гепатитын үед азатиоприн эмчилгээг ямар нөхцөлд хориглох вэ?

- А. Нас бага
- В. Жирэмсэн бол
- С. Цэвэршсэн бол

/82./ Маастрихтийн III удирдамжийн II хувилбарын эмчилгээний схемыг сонгоно уу?

- А. Омепразол+кларитромицин+метронидазол

- В. Денол+омепразол+кларитромицин+метронидазол
- С. Цемитидин+кларитромицин+метронидазол
- Д. Денол+ кларитромицин+метронидазол
- Е. Омепразол+кларитромицин+тетрациклин

/83./ Сульфасалазин ямар үйлдэлтэй вэ.

- А. Гэдэсний хөдөлгөөн зохицуулах
- В. Эмгэг флорын ургалт саатуулна
- С. Дархлаа дарангуйлна
- Д. Гэдэсний цусан хангамж сайжирна
- Е. Нянгийн ба үрэвслийн эсрэг үйлчилнэ

/84./ Нойр булчирхайн цочмог үрэвслийн үед аль иммунодепрессантыг хэрэглэх вэ?

- А. Делагил
- В. Имуран
- С. Циклофосфамид
- Д. Левамизол
- Е. 5 фторурацил

/85./ Элэгний хатуурлын үед гарах хүндрэлүүдийг тохиолдох давтамжаар нь зөв дараалуулсан хувилбарыг сонго.

А. Нянгийн перитонит, гиперспленизм, улаан хоолойн өргөссөн венээс цус алдах, элэгний эсийн дутагдал

В. Элэгний эсийн дутагдал, улаан хоолойн өргөссөн венээс цус алдах, гиперспленизм, нянгийн перитонит

С. Гиперспленизм, элэгний эсийн дутагдал, нянгийн перитонит, улаан хоолойн өргөссөн венээс цус алдах

/86./ Цэсний хүүдйд холестеролын чулуу үүсэх эмгэг жам аль нь вэ?

А. Цэсний найрлаганд триглицерид, холестерол ихсэж, цэсний хүүдийн хөдөлгөөн ихсэх

- В. Холецистокинин болон соматостатин зэрэг ялгарах
- С. Эндогенный простогландины дутагдал үүсэх, Оддын хуниас сулрах
- Д. Цэс холестеролоор ханан, цэсний хүүдийн зогсонгишил үүснэ
- Е. Огцом жин нэмэх, Са дутагдах

/87./ Гистамин дотоод шүүрлийн ямар эсээс ялгарах вэ?

- А. ЕС эс
- В. ECL эс
- С. G эс
- Д. P эс
- Е. D эс

/88./ Элэгний архаг эмгэг үүсгэдэг хамгийн гол шалтгаан аль нь вэ?

- А. Элэг гэмтээх вирүс
- В. Архи
- С. Удамшил
- Д. Элэг гэмтээх хорт бодис

/89./ APUD тогтолцооны P эс ямар даавар ялгаруулж, физиологийн ямар үүрэг гүйцэтгэх вэ?

- А. Серотонин ялгаруулж, салст ялгаралтыг сайжруулна
- В. Гастрин ялгаруулж, давсны хүчил ялгаралт болон пепсиногеныг идэвхжүүлнэ

- C. Бомбезин ялгаруулж, нойр булчирхайн шүүрлийг идэвхжүүлнэ
  - D. Секретин ялгаруулж, давсны хүчил ялгаралтыг саатуулна
  - E. Соматостатин ялгаруулж уургийн нийлэгжилтийг саатуулна
- /90./ Өвчтний хэвлийд хатгалт хийж 6 л шингэн авсан үед 20% альбумин хэдэн гр-г нөхөж хийх вэ?
- A. 50
  - B. 100
  - C. 200
  - D. 300
  - E. 400
- /91./ Гипокортицизмын шалтгааныг нэрлэ
- A. Бөөлжих
  - B. Глюкокортикойд эмчилгээг гэнэт хасах
  - C. Эозинофиль эсийн хавдар
  - D. Глюкостерома
  - E. Аменоррей
- /92./ Гипокортицизмын үед анаболитик эмчилгээг ямар зорилгоор хийдэг вэ?
- A. Хоол боловсруулах замын шүүрлийг ихэсгэх
  - B. Гликолизыг бууруулах
  - C. Липолизыг бууруулах
  - D. Протеолизыг бууруулах
  - E. Глюконеогенезыг ихэсгэх
- /93./ Бамбайн даавруудын ялгарлыг ихэсгэх үйлдэлтэй эсрэг биеийг нэрлэнэ үү
- A. тиреоглобулины эсрэг бие
  - B. микросомын эсрэг бие
  - C. ТТГ-ы рецепторын эсрэг бие
  - D. бамбайн өсөлтийг идэвхжүүлэгч эсрэг бие
  - E. коллоидын эсрэг бие
- /94./ Кетоацидозын комын үед тохирох хариултыг сонго
- A. Шөрмөсний рефлекс арилна
  - B. Булчин суларна
  - C. Артерийн даралт ихэснэ
  - D. Хөлрөлт нэмэгдэнэ
  - E. Биеийн халуун буурна
- /95./ Бодисын солилцооны хам шинж илэрсэн хүмүүс ямар өвчнөөр нас барах магадлал нь эрүүл хүмүүсээс илүү байдаг вэ?
- A. Сүрьеэ
  - B. Чихрийн шижин хэвшинж 1
  - C. Хорт хавдар
  - D. Тархмал хордлогот бахуу
  - E. Зүрхний шигдээс
- /96./ Гипокортицизмын үед лабораторийн шинжилгээнд илрэх өөрчлөлт
- A. Альбумин ихсэнэ
  - B. Натри ихсэнэ
  - C. Глобулин буурна
  - D. Кали ихсэнэ

Е. Холестерин ихсэнэ

/97./ Гипогликемийн комын үед илрэх шинж

- А. Арьс хуурай
- В. Цусны даралт буурна
- С. Гүнзгий, шуугисан амьсгал
- Д. Хүүхэн хараа өргөснө
- Е. Хэл хуурай

/98./ Гиперкортицизмын үед дааврын шинжилгээнд гарах өөрчлөлт

- А. 17-ОКС буурах
- В. 17-КС буурах
- С. АКТГ буурах
- Д. Кортизол буурах
- Е. Альдостерон ихсэх

/99./ Тархмал хордлогот бахуугийн үед зүрх судасны талаас ямар өөрчлөлт илрэх вэ?

- А. брадикарди
- В. зүрхний авиа бүлэг
- С. пульсийн даралт багасах
- Д. цусны даралт багасах
- Е. зүрхний авиа тод

/100./ Өөхөн эдийн хэвийн хэмжээ эрэгтэй эмэгтэй хүнд биеийн жингийн хэдэн хувийг эзлэх вэ?

- А. эрэгтэй хүнд 0-10%, эмэгтэй хүнд 5-15%
- В. эрэгтэй хүнд 5-15%, эмэгтэй хүнд 10-20%
- С. эрэгтэй хүнд 10-20%, эмэгтэй хүнд 15-25%
- Д. эрэгтэй хүнд 15-25%, эмэгтэй хүнд 20-30%
- Е. эрэгтэй хүнд 20-30%, эмэгтэй хүнд 25-35%